

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮР ДҮНД ХИЙХ АУДИТ**

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Үндэсний аудитын газар
2016 он**

Агуулга

Агуулга	1
Аудитын нэр, код	2
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	2
Аудитын зорилт	2
Хамрах хүрээ	2
Үндсэн мэдээлэл	3
Эрсдэлийн үнэлгээ	4
Арга зүй	4
Аудит хийхэд ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	5
Гүйцэтгэх хугацаа	5
Багийн бүрэлдэхүүн	5
Тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам	5
Шаардагдах хөрөнгө, нөөц	5

Хавсралт №1 Эрсдэлийн үнэлгээ
Хавсралт №2 Асуудлын шинжилгээ
Хавсралт №3 Арга зүй
Хавсралт №4 Хөтөлбөр

БАТЛАВ. МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр:

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

2. Аудитын код:

ҮАГ-НАГ/2016/03-НА/

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах тухай” 1 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт:

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон, Батлан хамгаалахын сайдын 2009 оны 290 дүгээр тушаалаар баталсан Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах журмаар тодорхойлсон “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”, “Байгаль орчныг хамгаалах сан”, “Сургалтын төрийн сан”, “Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-гуудын үйл ажиллагаа, эдгээр сангаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Хууль, эрх зүйн зохицуулалт нь үйл ажиллагааг бүрэн хангаж байгаа эсэх;
- Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж байгаа эсэх;
- Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасны дагууд зарцуулж, үр дүн гарч байгаа эсэх;
- Дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.

5. Хамрах хүрээ:

Аудитад БОНХАЖЯ, БХЯ, ХЯ, БСШУЯ, “Байгаль орчныг хамгаалах сан”, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”, “Сургалтын төрийн сан”, “Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-гууд болон аймаг, нийслэлийн холбогдох харьяа байгууллагууд нь 2015 он болон 2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар хамрагдна.

6. Үндсэн мэдээлэл:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар нийт 26 санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналттай холбогдсон харилцааг зохицуулж байна.

“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”

“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуулийн 21-26 дугаар зүйлийг үндэслэн 2010 онд Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан байгуулагдаж Засгийн газрын 2011 оны 117 тоот тогтоолоор *“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”*-ыг баталсан байна.

“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуульд заасны дагуу, уг сангийн санхүүгийн удирдлагын үүргийг Хөдөлмөрийн сайд эрхлэх бөгөөд сангийн хөрөнгийн зарцуулалтад боловсрол, санхүү, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл хяналт тавьж ажиллаж байна.

2015 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр аймаг, нийслэлд байрлах 28 хувийн болон төрийн өмчит мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн хувьсах зардлын санхүүжилтэд 3.2 тэрбум төгрөг, 71 мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн 37529 суралцагчдын тэтгэлгийн санхүүжилтэд 7.9 тэрбум төгрөгийн санхүүжилтүүдийн тус тус олгосон байна.

“Байгаль хамгаалах сан”

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасныг үндэслэн Засгийн газрын 1998 оны 188 дугаар тогтоолоор *“Байгаль хамгаалах сан”*-г анх байгуулж, 2012 оны 189 дүгээр тогтоолоор *“Байгаль хамгаалах сан”*-гийн журам болон зохион байгуулалт, орон тооны хязгаарыг, Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар сангийн “Удирдах зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг тус тус баталсан байна.

Байгаль орчны төлөв байдлын өөрчлөлтийг судлан тогтоох, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хорт нөлөөллийг багасгах дэвшилтэт технологи нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэн иргэдэд экологийн боловсрол олгох чиглэлээр сангийн хөрөнгийг оновчтой үр ашигтай зарцуулахад тус сангийн зорилго оршиж байна.

Тус сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлсэн сан гэж зааснаар 2015 онд 2,678.2 сая, 2016 онд 1,900.0 сая төгрөг батлаж үйл ажиллагаанд зориулан зарцуулсан байна.

“Сургалтын төрийн сан”

Сургалтын төрийн сан нь 1993 онд анх байгуулагдаж Монгол Улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох үйлчилгээг үзүүлдэг байна.

Тус сан нь Монгол Улсын хууль, Засгийн газраас *“Дээд боловсролын санхүүжилт нийгмийн баталгааны тухай”*, *“Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай”*, *“Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*, *“Зарим хүмүүсийг Сургалтын төрийн сангийн зээл, түүний хүүгийн төлбөрөөс чөлөөлөх тухай”* зэрэг журмыг мөрдөж ажилладаг байна.

Сургалтын төрийн сан нь 2011-2015 онд дотоод, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын санхүүжилтэд 641.3 тэрбум төгрөгийг төсөвлөснөөс 942.8 мянган суралцагчид 573.7 тэрбум төгрөгийн санхүүжилтыг зарцуулснаас 91.2 хувь буюу 523.3 тэрбум төгрөгийг тэтгэлэг тусламжид, 8.8 хувь буюу 50.4 тэрбум төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлээр олгожээ.

“Зэвсэгт хүчний хөгжлийн сан”

МУ-н Ерөнхийлөгчийн 2006 оны 304 дүгээр зарлигаар “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-т “Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-г байгуулах зорилт тусгагдсанаар тус сангийн эрх зүйн орчны эхлэл тавигдаж, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг үндэслэн Батлах хамгаалахын сайдын 2009 оны 290 дүгээр тушаалаар сангийн журам, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсанаар сангийн үйл ажиллагаа эхэлсэн байна.

Сангийн удирдах зөвлөлийн хуралдаанаар сангийн 2015 оны орлого, зарлагын төлөвлөлтийг хэлэлцэж, БХС-ын 2015 оны А/98, А/179, А/267 дугаар тушаалаар Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн 2015 оны орлогын төлөвлөгөөг 35.0 тэрбум төгрөгөөр баталж, 28.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, 6.2 тэрбум төгрөгийн хэмнэлт болон он дамжсан үлдэгдэлтэй байна.

7. Эрсдэлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээ, өмнөх жилүүдийн санхүүгийн тайлан, ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “ДУНД” гэж үнэлэв. (Хавсралт №1-д үзүүлэв)

8. Арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандартыг ашиглахын зэрэгцээ захиалагч байгууллагуудын төсөл арга хэмжээний төлөвлөлтийн баримт материалд судалгаа хийх, хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, гүйцэтгэгч байгууллагын тайлан, ажлын гүйцэтгэлийн баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, түүвэрчлэн шалгаж үр ашигт байдлыг үнэлэхийн зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу биет болон баримтат нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

9. Аудит хийхэд ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Дараах хууль, эрх зүйн акт болон шаардлагатай бусад баримт бичгийг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль;
- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам;
- Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах журам;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Гадаад зээл, тусламжийг зохицуулах тухай хууль;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

10. Гүйцэтгэх хугацаа:

Аудитын төлөвлөлтийг 2016 оны 6 дугаар сарын 25-нд эхэлж, талбарын ажлыг 8 дугаар сарын 15-аас, тайлагналын үе шатны ажлыг 10 дугаар сарын 10-аас 2016 оны 10 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэн Аудитын зөвлөлд танилцуулан, МУЕА-ын тушаалаар баталгаажуулж 2016 оны 11 дүгээр сарын 11-нд УИХ-д хүргүүлнэ. (Хавсралт №4-д үзүүлэв)

Орон нутгийн Аудитын газрууд тайлангаа 2016 оны 10 дугаар сарын 10-ны дотор ҮАГ-ын Нийцлийн аудитын газарт файлаар (bayarmaab@audit.gov.mn, tserennamjilts@audit.gov.mn) хаягаар болон цаасаар ирүүлнэ.

11. Багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Алтанзул хянан удирдаж, аудитын менежер З.Ариунзаяа аудитын стандартыг хангуулж, ахлах аудитор Ш.Энхтайван аудитыг ахалж тайланг нэгтгэх ба шинжээч М.Туул, Ц.Цэрэннамжил, Б.Баярмаа болон орон нутгийн аудитын газруудын аудитор, шинжээч нар гүйцэтгэнэ.

13. Тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

Тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, зөвлөмж, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдэх бөгөөд тайлангийн төслийг Аудитын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, МУ-ын Ерөнхий аудиторт танилцуулна.

13. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц:

А. Боловсон хүчин:

- ҮАГ: Аудитор, шинжээч 6 хүн – 390 хүн/өдөр
- Орон нутаг: Аудитор, шинжээч 66 хүн – 2640 хүн/өдөр


Б. Санхүүгийн нөөц:

- Цалин – 82,500.0 мянган төгрөг
- Бичиг хэрэг – 400.0 мянган төгрөг
- Томилолтын зардал – 5,580.0 мянган төгрөг /ҮАГ/


В. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, видео камер, зургийн аппарат болон бусад техник хэрэгсэл

Аудитын төлөвлөгөөг




Танилцсан:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ДЭД ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.БАТТУЯА

Хянасан:

НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.АЛТАНЗУЛ

Боловсруулсан:

АУДИТЫН МЕНЕЖЕР
 З.АРИУНЗАЯА
АХЛАХ АУДИТОР
 Ш.ЭНХТАЙВАН
ШИНЖЭЭЧ
 М.ТУУЛ
 Ц.ЦЭРЭННАМЖИЛ
Б.БАЯРМАА